

БАТЛАВ  
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Ж.ЛХАГВАСҮРЭН

2024 оны 05 дугаар сарын 13

“СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭГДСЭН САМБАР ХИЙЖ БАЙРЛУУЛАХ”  
АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 дугаар сарын 13

Дугаар 08

Улаанбаатар хот

1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.2, 41 дүгээр зүйлийн 41.3, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоол
2.	Байршил, тоо хэмжээ	<ul style="list-style-type: none"><li>Чингэлтэй дүүргийн 1-24 хорооны нутаг дэвсгэрт ЧД-ийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 28 дугаар тогтоолоор батлагдсан байршил</li><li>Нийт 672 самбар</li></ul>
3.	Зориулалт, хүчин чадал	Сонгуулийн нэр дэвшигчдийн сурталчилгааны материалыг байрлуулах
4.	Төсөл боловсруулах үе шат, хугацаа	1 үе шаттай: 1. Батлагдсан зураг, төсвийн дагуу сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарыг хийж гүйцэтгэн, байршуулах
5.	Захиалагч байгууллага	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
6.	Хөрөнгийн эх үүсвэр	Дүүргийн төсөв
7.	Тухайн ажилд тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"><li>Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нутаг дэвсгэрт ИТХ-аар баталсан байршил самбаруудыг суурилуулна.</li><li>Хотын стандарт, хяналтын газраас батлагдсан холбогдох стандартуудыг мөрдөж ажиллах.</li><li>Нэр дэвшигчийн зурагт хуудас нь А3 хэмжээтэй, байрлалын хувьд өндрөөр нь буюу босоо байдлаар байршуулахаар тооцох.</li><li>Хэсэгчлэн бэлтгэсэн 7 ширхэг хэсгүүд нийлж 1 самбар болно.</li><li>Хэсэгчлэн бэлтгэсэн 7 ширхэг хэсгийг байршуулахдаа залгаа байдлыг алдагдуулахгүйгээр байрлуулж хооронд холбож бэхэлсэн байна.</li><li>Хэсэгчлэн бэлтгэсэн нэг хэсэгт босоо нэг эгнээнд 3 нэр дэвшигч байхаар тооцож, нийт 8 эгнээтэй 24 нэр дэвшигч байхаар бэлтгэнэ.</li><li>Үндсэн самбар төмөр хийцтэй байна.</li><li>Самбарын хөл, рам, гөлмөн төмөрийг цагаан саарал өнгөөр будна. Самбар дахь зураг хоорондын тусгаарлах зураасын хэмжээ 1.5см өргөнтэй, хар саарал өнгөтэй, үндсэн самбар нь газраас 80см-ээс доошгүй өндөр байрлах.</li><li>Самбарын А3 хэмжээтэй хүрээнүүд дотор 1-168 хүртэл дугаарыг дээрээс доош цувруулах байдлаар бичнэ.</li></ol>

		<p>10. Нэгдсэн самбар нь нэр дэвшигчдийн зурагт хуудсыг зөвхөн нэг талд нь байршуулахаар тооцно.</p> <p>11. Нэгдсэн самбарын нийт уртаас шалтгаалан зөөж тээвэрлэх байршуулахад тохиромжтой байдлаар хэсэгчлэн бэлтгэнэ.</p> <p>12. Нэгдсэн самбарыг байршуулахдаа явган хүний зам, замын тэмдэг тэмдэглэгээг хааж, халхлахгүйгээр, бэхэлгээг бүрэн хийх шаардлагатай.</p> <p>13. Зөөвөрлөн шилжүүлж дахин ашиглах боломжтойгоор төлөвлөх.</p>
8.	Галын аюулгүй байдлын нөхцөл	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21.02.02/, /БНБД 21.01.02/ Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244:1994
9.	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Монгол улсын хуулиуд: Монгол улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль Стандарт, норм дүрэм: Гадна мэдээллийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага UCS1403B Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий БД 32-101-17 Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-03-04 Ус үл нэвтрүүлэх хуйлмал материал ТУ 5774-002-13157915-98 Гөлмөн төмөр МН 3154-1904 Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04 Барилга орчны тохижилтын ажил БНБД 3,01,06-90 Бусад холбогдох норм дүрмүүд, стандартууд</p>
10.	Төслийн иж бүрдэл	<p>Одоогийн байдлын судалгаа Ажлын зураг Төсөв Тайлбар бичиг Батлагдсан байршлын дагуу самбарыг байршуулах Бусад холбогдох материалууд</p>
11.	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох

ХЯНАСАН:

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.ЦЭРЭННАМЖИЛ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

М.ТУЯА